Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1: ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ШИЛДЭГ АРГА БАРИЛЫГ ХЭРЭГЛЭХ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЗАМААР АГЕНТЛАГИЙН АППАРАТЫГ ЦОМХОН, ЧАДВАРЛАГ БАГ БҮРДҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ, ТУС ГАЗРЫН ДАРГЫН ЭРХЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАСГИЙН ГАЗРААС ТӨСӨВЛӨСӨН ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙГ ХУВААРИЛАН ЗОХИЦУУЛАХ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГ ЭРХЛЭХ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ;** | | | | | | | |
| **Зорилго 1.1 Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах** | | | | | | | |
| 1. | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | - | Төлөвлөгөө | 0 | 1 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар батлуулсан. | 100 |
| 2. | Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | - | ТЗ ангиллын албан тушаалын тодорхойлолт-8, ТҮ ангиллын албан тушаал-26 | 0 | 34 | Тус газрын төрийн үйлчилгээний 26 албан тушаалын тодорхойлолтыг 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан.<br>Төрийн захиргааны 9 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Тус газрын 2023 оны А/90 дүгээр тушаалаар төрийн үйлчилгээний 6 албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Нийт 41 албан тушаалын тодорхойлолт батлагдсан. | 100 |
| 3. | Агентлагийн даргын шуурхай зөвлөлийг зохион байгуулах, | - | Хурлын тоо | 0 | Тухай бүр | Удирдлагын зөвлөлийн хурлыг 7 хоног бүрийн Даваа гараг бүр зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, дүнг мэдээлэх | | | | | байгуулж, хурлаас өгсөн үүрэг даалгаварт хяналт тавьж, гарсан үр дүнг тухай бүр мэдээлж ажилласан. | |
| 4. | Байгууллагын сул орон тоог нөхөх ажлыг тухай бүр зохион байгуулах | Улсын төсөв, цалин | Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | 0 | 174 | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын сул орон тоо гарах бүрд холбогдох хууль, журмын хүрээнд сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Төрийн захиргааны албан хаагч-9, Төрийн үйлчилгээний албан хаагч-153, чөлөөлөгдсөн 38, түр чөлөөлөгдсөн 6, нийт 206 албан хаагчийг сонгон шалгаруулж, томилон ажилласан. | 100 |
| 5. | Албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах | - | Үнэлгээ хийсэн тоо | 0 | 2 | Тус газрын 2023 оны Б/112, Б/113 дугаар тушаалаар үнэлгээний баг томилон албан хаагчдын хагас, бүтэн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг холбогдох журмын дагуу үнэлж, Б/116, Б/113 дугаар тушаалаар тус тус урамшуулал олгосон.<br>Тус газрын 2023 оны А/87 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмыг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. | 100 |
| 6. | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналд нэр дэвшүүлэн хүргүүлэх ажлыг зохион байгуулах | - | Олгосон шагналын бүртгэл хийгдсэн байх | 0 | 6 | Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 01/200 дугаар албан бичгээр "Мэдээлэл харилцаа холбооны тэргүүний ажилтан тэмдгээр" 1, "Жуух бичиг"-ээр 7, "Мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарын тэргүүн"-ээр 2 албан хаагчийг тодорхойлж, шагнуулсан. | 100 |
| 7. | Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх | Байгууллагын үйл ажиллагааны | Тайлангийн тоо | 0 | 1 | Байгууллагын хүний нөөцөд тулгуурлан төрийн цахим үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийг судлах, үнэлэх, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | урсгал зардал | | | | сайжруулах зорилгоор 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд Нийслэлийн 16 цэг, 21 аймгийн "ХУРДАН" цэгээр дамжуулан нийт 4,646 иргэн /Нийслэл 1,628, орон нутаг 3,018/-ийг судалгаанд хамруулж хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайланг нэгтгэн боловсруулсан. | |
| 8. | Хөдөлмөрийн дотоод журмыг батлах | - | Журмын тоо | 0 | 1 | Тус газрын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/02, 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/103 дугаар тушаалаар тус тус "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталсан. | 100 |
| 9. | Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах | - | Хурлын тоо | 0 | 2 | 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалаар "Өмч хамгаалах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг баталсан. Тус газарт төрийн болон орон нутгийн байгууллагаас эд хөрөнгө, тоног төхөөрөмж шилжүүлэх шийдвэр, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцож балансаас баланс хооронд шилжүүлэх шийдвэр, санал гараагүй тул өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудал үүсээгүй болно. | 100 |
| 10. | Эд хөрөнгийн тооллого хийх комиссын бүрэлдэхүүнийг батлах | - | Хурлын тоо | 0 | 1 | Тус газрын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/32, 12 дугаар сарын 01-ний өдрийн А/111 дүгээр тушаалаар "Эд хөрөнгийн тооллогын комисс"-ын бүрэлдэхүүнийг баталж хурлыг зохион байгуулсан. Комиссын хурлаар байгууллагын нийслэл, орон нутаг дахь эд хөрөнгийг бүртгэлжүүлэх, тооллого хийх тухай хэлэлцэн жилд 2 удаа тооллого хийхээр шийдвэрлэсэн. Комиссын шийдвэрийн дагуу 6,11 дүгээр сард хоёр удаагийн тооллого хийсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11. | Байгууллагын албан бичгийн боловсруулалт, бичгийн эргэлтэд байнгын хяналт тавьж ажиллах | - | Тайлант жилд үүссэн дотоод, гадаад бичгийн эргэлтэд хяналт тавьж ажилласан байх | 0 | 310 | Байгууллагын хэмжээнд 346 албан бичиг хүлээн авч, 388 албан бичигт дугаар олгон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 117 "А" тушаал, хүний нөөц, дотоод үйл ажиллагаатай холбоотой 209 "Б" тушаалыг тус тус баталж, хяналт тавин ажилласан. | 100 |
| 12. | Баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулах | - | Хурлын тоо/комиссын тоо | 0 | 1 | Тус газрын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/105 дугаар тушаалаар "Баримт нягтлан шалгах комисс"-ыг байгуулж, нэг удаа хурал зохион байгуулсан. Тус хурлаар Баримт нягтлан шалгах комиссын журмыг танилцуулж, 2023 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан баталсан. | 100 |
| 13. | Архивын бүрдүүлэлтэд хяналт тавьж, баяжилтыг хийж ажиллах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлах | - | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын тоо | 0 | 1 | Тус газрын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/115 дугаар тушаалаар "Архивын үйл ажиллагаанд мөрдөх журам"-ыг баталж, Баримт нягтлан шалгах комиссын хурлаар "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг баталж мөрдлөг болгон ажилласан. | 100 |
| **Зорилго 1.2 Албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 14. | Албан хаагчдыг мэргэшлийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | Байгууллагын үйл ажиллагааны зардал, тэтгэлэгт сургалтууд | Албан хаагчдын тоо | 0 | 20 | 1.Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 10 албан хаагч;<br>2.Удирдлагын академийн богино, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 13 албан хаагч;<br>3.Архивын ерөнхий газрын Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад 1 албан хаагч;<br>4.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санхүүжилтээр зохион байгуулагдсан Python fundamentals | 100 |



22

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | программчлалын хэлний сургалтад 1 албан хаагч буюу нийт 25 албан хаагч холбогдох сургалтад хамрагдсан. | |
| 15. | Байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тогтвортой ажиллах чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулах | Улсын төсөв, цалин | Баримт бичгийн тоо | 0 | 1 | Тус газрын 2023 оны 10 дугаар сарын А/93 дугаар тушаалаар "Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн 5.1.8, Хөдөлмөрийн дотоод журмын 7.20 дахь хэсэгт заасны дагуу 8 албан хаагчийн нийгмийн баталгааг хангаж ажилласан. | 100 |
| 16. | Байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн харилцааны асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулж газрын удирдлагад танилцуулах, холбогдох арга хэмжээ авах | - | Хөдөлмөрийн харилцаатай холбоотой албан хаагчаас ирүүлсэн өргөдлийн хэрэгжилт хангагдсан байх | 0 | 155 | Төрийн захиргааны албан хаагч-9, Төрийн үйлчилгээний албан хаагч-153, чөлөөлөгдсөн 38, түр чөлөөлөгдсөн 6, нийт 206 албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдөл, хүсэлтийг хүлээн авч бүртгэн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. Байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн харилцааны асуудлыг шийдвэрлэх талаар Хөдөлмөрийн гэрээ, нууцын гэрээг боловсруулан баталсан. | 100 |
| 17. | Байгууллагын албан хаагчдын ёс зүйн байдалд хэм хэмжээнд хяналт тавих "Ёс зүйн зөвлөл"-ийг байгуулах | - | Зөвлөлийн тоо | 0 | 1 | Тус газрын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/18 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам батлаж 07 дугаар сарын 26-ны өдрийн А/74 дугаартай тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг байгуулсан. Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан биелэлт хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100 |
| 18. | Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах | - | Албан хаагчдын тоо | 0 | 70 | Тус газрын 2023 оны А/110 дугаар тушаалаар нийт 57 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан. | 100 |



23

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэл, орон нутгийн нийт 16 албан хаагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хувиараа хамрагдсан байна. | |
| 19. | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр", хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 2023 оны А/93 дугаар тушаалаар баталсан. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. | 100 |
| 20. | Албан хаагчдыг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах, албан тасалгааны асуудлыг шийдвэрлэх | - | Хурлын тоо | 0 | 3 | Тус газрын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/38 дугаар тушаалаар ажлын байрны асуудлыг шийдвэрлэх ажлын хэсгийг байгуулж 7 удаагийн хурал зохион байгуулж УБ каса капитал ХХК-ийн СБД, 6 дугаар хороонд байрлах 580м.кв талбайг түрээслэн ажиллаж байна. Энэхүү асуудлын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд албан бичиг хүргүүлж мэдэгдсэн. | 100 |
| 21. | Албан хаагчдын цалин, хоол унааны зардлыг нэмэгдүүлэх санал хүргүүлэх | -тог | Саналын тоо | 0 | 2 | 1.Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Б/58 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг 10-20 хувиар, Б/130 дугаар тушаалаар 20-25 хувиар тус тус нэмэгдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2.Албан хаагчийн өдрийн хоолны хөнгөлөлтийг тус газрын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/04 дүгээр тушаал, 11 дүгээр сарын 01- | 100 |



24

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ний өдрийн А/103 дугаар тушаалаар тус тус нэмж баталсан.<br>3.Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журмыг тус газрын 2023 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн А/87 дугаар тушаалаар баталж сар бүр ТҮ-6-ТҮ-8 ангилал дахь албан хаагчдад үндсэн цалингийн 25% хүртэлх нэмэгдлийг олгон ажиллаж байна. | |
| **Зорилго 1.3 Хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх** | | | | | | | |
| 22. | Байгууллагын бодлогын хэрэгжилт болон бусад баримт бичгийг холбогдох албан хаагчидтай хамтран боловсруулах ажлыг зохион байгуулах | - | Ажлын хэсгийн тоо | 0 | 3 | Тус газрын 2023 оны А/81 дугаартай тушаалаар Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>“Төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журам”, “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”, албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтын төслийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 01/246 дугаартай албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Тус газрын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/115 дугаар тушаалаар “Архивын үйл ажиллагаанд мөрдөх журам”, 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/105 дугаар тушаалаар “Баримт бичиг нягтлан шалгах комиссын журам”, 02 дугаар сарын 10-ны өдрийн А/02, 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/103 дугаар тушаалаар тус тус “Хөдөлмөрийн дотоод журам”, А87 дугаар тушаалаар “Төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам", А18 дугаар тушаалаар "Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам" А/28 дугаар тушаалаар Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам", "Кибер аюулгүй байдлыг хангах дотоод журам"-ыг тус тус баталсан. | |
| 23. | Салбарын үйл ажиллагааг зохицуулах хуулийн төсөлд санал өгөх төсөл боловсруулах, хянах | - | Саналын тоо | 0 | 2 | Улсын Их Хурлаар батлагдсан төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 120 хуулийг дагаж өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөлд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт, цаашид төлөвлөсөн ажилд тусгагдах саналын томьёоллыг боловсруулж, холбогдох мэдээллийг Инновац, цахим бодлогын байнгын хороонд танилцуулж, холбогдох талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгах саналын томьёоллыг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>"Соёлын салбарын нэгдсэн дата удирдлагын систем" болон "Соёлын салбарын статистикийн мэдээллийн систем" хөгжүүлэх төслийн саналтай танилцаж 11 дүгээр сарын 17-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хариу хүргүүлсэн. | 100 |



26

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24. | Агентлагийн даргын эрхлэх асуудлын хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх ашгийг хамгаалан оролцох | - | Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тоо | - | Тухай бүр | Хууль, шүүхийн байгууллагад тус байгууллагатай холбоотой хэрэг маргаан үүсээгүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй болно. | 100 |
| 25. | Агентлагийн удирдлага болон албан хаагчдад хууль, эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх | - | Албан хаагчдын боловсруулсан баримт бичгүүдийн төслийг хянаж, хууль эрх зүйн үндэслэлийг хянасан байх | 0 | Эрх зүйн асуудлаар зөрчилтэй баримт бичиг гаргуулахгүй байна. | Албан хаагчдын боловсруулсан 388 албан бичиг, А тушаал 117, Б тушаал 209, нийт 714 албан бичгийн төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг тухай бүр хянан, зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>11 дүгээр сарын 01-ний өдрийн А/103 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, Монгол улсын засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоол, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 98 дугаар тушаалаар Аргачлал, Загваруудыг танилцуулах, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг сургалтад байгууллагын нийт албан хаагчийг хамруулж 3 удаагийн сургалт зохион байгуулсан. | 100 |
| 26. | Албан хаагчдад салбарын хууль тогтоомжийн талаар мэдээллийг тухай бүрд өгөх, шаардлагатай сургалтыг зохион байгуулах | - | Сургалтын тоо | 0 | 10 | Тус газрын тушаалаар баталсан байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх “Архивын үйл ажиллагаанд мөрдөх журам”, “Баримт бичиг нягтлан шалгах комиссын журам”, “Хөдөлмөрийн | 100 |



27

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотоод журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам", "Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам" зэрэг журмыг танилцуулах сургалтыг байгууллагын нийт албан хаагчид цахим болон танхим хэлбэрээр тухай бүр зохион байгуулсан.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар баталсан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг байгууллагын нийт албан хаагчдад танилцуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж нийслэл, орон нутгийн 22,438 иргэн, албан хаагчийг сургалтад хамруулсан.<br>Монгол улсад Ухаалаг засаглал, Ухаалаг эдийн засаг, Ухаалаг хөдөлгөөнт холбоо, Ухаалаг дэд бүтэц, Ухаалаг амьдралын хэв маяг, Ухаалаг орчны хүрээнд анхны "Аймгуудын цахим шилжилтийн тайлан-2023" бэлтгэн иргэд, олон нийтийн хүртээл болгох ажилд байгууллагын 21 аймаг хэлтсийн дарга, албан хаагчид шаардлагатай мэдээллийг нэгтгэж хамтран ажилласан.<br>Мөн нийт албан хаагчдад Цахим хөгжлийг дэмжих хуулийн талаар холбогдох сургалтыг 3 удаа зохион байгуулсан. | |
| 27. | Нийтийн албан тушаалтны 2022 оны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар хүлээн авч, тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх | - | Мэдүүлэг гаргагчийн тоо | 0 | Тухай бүр | Тус газрын 46 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2022 оны байдлаар хуулийн хугацаанд бүрэн шинэчлэн гаргуулж, "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг", "Албан тушаалтнуудын 2022 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /хураангуй/", "Мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны нэрсийн жагсаалт", "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл"-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | |
| 28. | Авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг тайлагнасан байх | - | Тайлангийн тоо | 0 | 2 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж байгаа учир давхар авлигын эсрэг төлөвлөгөө батлах шаардлагагүй гэсэн чиглэлийг Авлигатай тэмцэх газраас өгсөн. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор авлигатай тэмцэхийг уриалсан утга агуулга бүхий 4 төрлийн видео шторкийг байгууллагын албан ёсны цахим хуудаст болон 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсүүдийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийт 88 удаагийн нийтлэлийг иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газраас "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49-р тогтоолд заасан "Шил ажиллагаа"-ны хүрээнд нийтэд ил тод байхаар заасан мэдээллүүдийг нээлттэй болгох ажилд 21 аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж shilen.gov.mn цахим хуудаст байршуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29. | Албан тушаалтнаас захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тайлбарыг гаргуулж, шилэн дансны, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдээллийг бүртгэх | - | Хуулийн хугацаанд мэдүүлэх | 0 | Тухай бүр | Албан тушаалтнаас захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тайлбарыг гаргуулж, шилэн дансны, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд 10 албан хаагчийн мэдээллийг бүртгэсэн. | 100 |
| **Зорилго 1.4 Хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих** | | | | | | | |
| 30. | Хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих | - | Шийдвэрлэсэн тоо | 0 | 10 | Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд тус газрын үйл ажиллагаатай холбоотой 3 гомдол ирүүлснийг хүлээн авч, ажлын 3 хоногийн дотор холбогдох журмын дагуу бүрэн шийдвэрлэсэн. | 100 |
| 31. | Байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх | - | Хандах төрлийн тоо | 0 | 5 | Байгууллагад хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 5 төрлийн цахим хэлбэр (албаны цахим шуудан, суурин утас 70122626, олон нийтийн цахим сүлжээний хаяг, операторын систем)-ээр хүлээн авч, шийдвэрлэн, холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн. | 100 |
| **Зорилго 1.5 Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах** | | | | | | | |
| 32. | Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах | 19,9 | Мэдээлэл, ярилцлага, нийтлэлийн тоо | 0 | 40 | Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдийг мэдээллээр хангах зорилгоор нийт 53 ажлыг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:<br>1."Монголын үндэсний олон нийтийн радио телевиз"-ийн "Өдрийн зочны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цаг" нэвтрүүлэгт байгууллагын төлөөлөл оролцсон;<br>2."Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын апликейшнд "ХУРДАН" цэгийн 6 шторкийг байрлуулсан;<br>3. Business.mn сэтгүүлийн 11 дүгээр сарын дугаарт байгууллагын үйл ажиллагаа, "ХУРДАН" цэгийн мэдээллийг бэлтгэн нийтлүүлсэн;<br>4.Олон нийтийн хэвлэл мэдээллийн 31 цахим хуудсанд "ХУРДАН" цэгийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг нийтлэх ажлыг зохион байгуулсан.<br>5."Цахим аймаг" бодлогын зөвлөмж, сургалт, үнэлгээний арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 аймагт ажиллаж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 21 мэдээ, нийтлэлийг иргэдэд хүргэсэн.<br>6."МОНЦАМЭ" агентлаг болон MNB телевизээд тус газрын төлөөлөл иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын зорилго, үр дүнгийн талаар мэдээлэл өгч ажилласан.<br>7.Нийслэл, орон нутаг, хилийн чанад, хилийн боомт дахь ХУРДАН цэг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэнтэй холбоотой 144 мэдээ, нийтлэлийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.<br>8.Орон нутгийн арга хэмжээ, нээлттэй хаалганы өдөрлөгтэй холбоотой 12 арга хэмжээ;<br>9. Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд зохион байгуулж буй "Хөдөөгийн сэргэлт" чуулганы | |



31

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд ЦХХХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар "ХУРДАН" төвийн үйл ажиллагааг иргэдэд танилцуулах арга хэмжээ;<br>10.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хамгийн том арга хэмжээ болох "ICT EXPO 2023"-д оролцон Аймгийн засаг дарга, Тамгын газрын дарга нар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга зэрэг нийт 541 хүнд байгууллагын үйл ажиллагааг танилцуулж зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан;<br>11."Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход<br>төр, иргэний нийгэм, залуучуудын бүтээлч хамтын оролцоо" залуучуудын хөгжлийн үндэсний есдүгээр чуулган;<br>12.Улаанбаатар олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2023;<br>13. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Админ-2023" арга хэмжээ;<br>14.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн экспо "Ability Expo" арга хэмжээнд тус тус оролцож хүн, хуулийн этгээдэд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгч ажилласан.<br>15.Монгол Улсын Их Хурлын гишүүдтэй, 21 аймгийн Засаг даргын тамгын газар, иргэдийн төлөөлөгчдийн хурал, төр, хувийн хэвшлийн бусад байгууллагуудтай уулзалт зохион байгуулж байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулсан. | |



32

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | Байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээний хаяг хөтлөлтийг хариуцан зохион байгуулах | - | Мэдээ, контентын тоо | 0 | 100 | 1.Салбарын бодлого, хуулийн танилцуулга, байгууллагын үйл ажиллагаа, сургалтын чиглэлээр хийж, хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай 380 мэдээ, мэдээллийг цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан 1,201,980 хүн, хуулийн этгээдийг мэдээллээр ханган ажилласан байна.<br>Байгууллагын албан ёсны цахим хуудас нийт 24,565, инстаграм хаяг 102 хэрэглэгчтэй бөгөөд тус цахим хаягаар дамжуулан Эстони Улсын Таллин хотод зохион байгуулагдсан "Tallin Digital Summit-2023" OGP буюу "Нээлттэй засгийн түншлэл" форум 6300, Катар улсын Доха хотноо дэлхийн 15 орны 29 баг өрсөлдсөн "Seeds for the future" 2023 хөтөлбөртэй холбоотой нэвтрүүлгийг 5200 хүн, хуулийн этгээдэд хүргэн ажилласан. | 100 |
| 34. | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | - | Арга хэмжээний тоо | 0 | 1 | Байгууллагын удирдлага "Орчин цагийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар үүсэж хөгжсөний 102 жилийн ой"-н арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт орж нийслэл, орон нутаг дахь албан хаагчдыг хамруулж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэн ажилласан. | 100 |
| 35. | Байгууллагын олон нийтийн цахим хаягийн албан ёсны тэмдэглэгээг авч албажуулах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Шийдвэрийн тоо | 0 | 1 | Байгууллагын албан ёсны цахим хуудсыг олон улсын цахим хуудас хөгжүүлэгч "Мета" компанийн холбогдох журмын шаардлагыг хангаан баталгаажуулсан тэмдэглэгээний зөвшөөрлийг авч тус цахим хуудсаар дамжуулан хүн, хуулийн этгээдэд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг дагаж гарсан тогтоол, дүрэм, журмын дагуу холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Мэдээллийн тоо | 0 | 45 | 1.Тус хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49-р тогтоолд заасан "Шил ажиллагаа"-ны хүрээнд олон нийтэд ил тод байршуулах мэдээллийг 100 хувь мэдээлэн ажилласан.<br>2.Тус газрын 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь Монгол Улсын Засгийн газраас "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49-р тогтоолд заасан "Шил ажиллагаа"-ны хүрээнд нийтэд ил тод байхаар заасан мэдээллүүдийг нээлттэй болгох ажилд 21 аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж shilen.gov.mn цахим хуудаст байрыг урагшлуулсан. | 100 |
| 37. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааг таниулах, зөвлөгөө, мэдээллээр хангах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран ажиллах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Хамран ажиллах байгууллагын тоо | 0 | 10 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааг таниулах, зөвлөгөө, мэдээллээр хангах зорилгоор Инновац, цахим бодлогын байнгын хороо, Улсын Их Хурлын тамгын газар, УИХ-ын даргын ажлын алба, УИХ-ын гишүүдийн ажлын алба, холбогдох яам, агентлаг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй Хүний ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Засаг даргын тамгын газар, "Шинэ | 100 |



34

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргэлтийн бодлогын хурдасгуур төв", Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, И-Клиник ХХК, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, И монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний Дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төв улсын үйлдвэрийн газар, "Монгол шуудан" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК, Төрийн банк, Засгийн газрын авто бааз, Монголын нотариатчидын танхим, Төрийн банк ХХК, Голомт банк ХХК, Хаан банк ХХК, Анагаахын шинжлэх ухааны их сургууль, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг, "Билэгт дөлгөөн" ХХК 1900-1950, "Юнител" ХХК, "Мобиком" ХХК, "Гэрэгэ систем" ХХК, "Түшиг" ХХК, "Сан энд три" ХХК, "Скай хайпермаркет" ХХК, "Да Хүрээ Трейд" ХХК, "Нисэх цагаан хаалга" ХХК, "Номин бизнес клуб" ХХК, "Олон Улсын Худалдаа Логистикийн төв" ХХК, "Хайнд Про" ХХК, "Метафорс" ХХК, "Чингис Жоней" ХХК, Фаро фаундэйшн ТББ, Ай Си Ти групп ХХК, Старт Сити ХХК, Эм Эл Си бизнес скүүл, Ай Эм Эс Эй ХХК, Эртэч Монгол ТББ, Смарт контракт ХХК, Кактус Пэй ХХК, МИАТ төрийн өмчит ХК зэрэг төрийн захиргааны 8, төрийн өмчийн оролцоотой 5 байгууллагатай тус тус хамтран ажилласан. | |



35

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын арга хэмжээ, төсөл хөтөлбөрийн зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, албан хаагчдыг хамруулах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Арга хэмжээний тоо | 0 | 4 | Салбарын арга хэмжээ, төсөл хөтөлбөрийн зохион байгуулалтад оролцох, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, албан хаагчдыг хамруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан.<br>1."Хөдөөгийн сэргэлт чуулган" арга хэмжээнд оролцож, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийг байршуулан, хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгч, мэдээллээр ханган ажилласан;<br>2. Салбарын ICT EXPO-2023 арга хэмжээний зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцож, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж нийслэл, орон нутаг дахь албан хаагчдыг бүрэн хамруулан ажилласан. Тус ажлын хүрээнд 21 аймаг дахь Аймгийн Засаг дарга, Тамгын газрын дарга нар, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга буюу нийт 541 хүнд байгууллагын үйл ажиллагааг танилцуулж зөвлөгөө, мэдээллээр хангасан.<br>3."ICT 2023" спортын арга хэмжээнд оролцож, олон нийтийн цахим сүлжээгээр холбогдох мэдээ, мэдээллийг цаг тухай бүр хүн, хуулийн этгээдэд хүргэн ажилласан;<br>4. 21 аймагт "Цахим аймаг" бодлогын зөвлөмж, сургалт, судалгаа, уулзалт, үнэлгээний ажлын зохион байгуулалтад оролцож холбогдох мэдээ, мэдээллийг цаг тухай бүр орон нутгийн хүн, хуулийн этгээдэд хүргэн мэдээллээр ханган ажилласан. | 100 |



36

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын санаачилгаар жил бүр зохион байгуулдаг "Засгийн газрын цом 2023" тэмцээнийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам хариуцан зохион байгуулахад спорт арга хэмжээний cup.gov.mn цахим хуудсыг хөтлөх, бүртгэл мэдээллийн ажлыг хариуцан ажилласан.<br>Нийслэл, орон нутгийн нийт 24 үйлчилгээний ажилтан, мэргэжилтэн албан хаагчид, удирдлагууд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба хамтран "Кибер тусгаар тогтнол" мэдээллийн аюулгүй байдлын үндэсний форумд хамруулсан.<br>Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Админ-2023" арга хэмжээнд албан хаагчдыг хамруулсан. | |
| **Зорилго 1.6 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах** | | | | | | | |
| 39. | Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Байнгын хорооны болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтийг Цахим хөгжил, харилцаа харилцаа холбооны яаманд хүргүүлэх | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Тайлангийн тоо | 0 | 6 | Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг 01/272, 01/297, 01/307, 01/352, 01/371 дугаартай албан бичгээр 5 удаа, цахим хэлбэрээр 11 удаа, нийт 16 удаагийн тайланг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 1.7 Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх** | | | | | | | |
| 40. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны | Байгууллагын үйл | Сургалтад хамрагдах | 0 | 5 | 1.2023 оны 03 дугаар сарын 17-ний өдрөөс 03 дугаар сарын 30-ны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гишүүнчлэл бүхий олон улсын болон бүс нутгийн байгууллагуудаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, семинар, сургалтад агентлагийн төлөөллийг хамруулах ажлыг зохион байгуулах | ажиллагааны болон зохион байгуулагч талын зардал | албан хаагчийн тоо | | | өдрүүдэд БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан "Ухаалаг засаглал" сургалтад холбогдох албан тушаалтныг хамруулсан. Тус албан хаагч нь Олон улсын туршлага судлан "Ухаалаг засаглал" сургалтын хүрээнд олж авсан мэдлэг ойлголтыг байгууллагын нийт албан хаагчдад танилцуулж мэдээллээр хангасан;<br>2.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамнаас зохион байгуулсан "Бүс ба Зам"-ын төслийн хүрээнд "Ухаалаг төр ба мэдээлэлжүүлэлт" семинарт 1 албан хаагч хамрагдсан.<br>3 Бүгд Найрамдах Эстони Улсын Таллин хотод "Дижитал саммит-2023" дээд хэмжээний уулзалтад тус байгууллагаас 2 албан хаагч хамрагдсан.<br>4.Катар улсын Доха хотноо "Seed of the future" 1000 инженер бэлтгэх хөтөлбөрт 1 албан хаагч хамрагдсан.<br>5.Тайвань улсын Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн сангаас "Ухаалаг хот 11" сургалт, семинарт 1 албан хаагч хамрагдсан.<br>6.Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх үүднээс БНСУ-д суугаа Элчин сайдын яамны консулын хэлтсийн байранд төрийн үйлчилгээний ТҮЦ машин байршуулах, цахим гарын үсэг ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх, төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулах ажлыг зохион байгуулах арга хэмжээнд 1 албан хаагч хамрагдсан. | |
| 41. | Монгол Улсын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас хэрэгжүүлж | Улсын төсөв, цалин | Хүргүүлсэн саналын тоо | 0 | 1 | Монгол Улсын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, | 100 |



38

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд агентлагийн албан хаагчдыг магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрт хамруулах эхний шатны сонгон шалгаруулалтад санал хүргүүлэх | | | | | хөтөлбөрийн хүрээнд агентлагийн албан хаагчдыг магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрт хамруулах санал Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлээгүй байна. | |
| 42. | Салбарын үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсад ирсэн гадаадын төлөөлөгчдийг хүлээн авах ёслол, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн ажиллах | Байгууллагын үйл ажиллагааны болон зохион байгуулагч талын зардал | Арга хэмжээний тоо | 0 | 3 | 1.Камбожийн Хант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Тажикстан Улсын төрийн дээд шатны албан хаагчид болон Швейцарын хөгжлийн агентлагийн бүрэлдэхүүнийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа, салбар байгууллага болон "ХУРДАН" цэгийн үйл ажиллагаатай танилцуулсан.<br>2.Тажикстан Улсын Аж үйлдвэр, технологийн тэргүүн дэд сайд Isojon Qurqonzoda болон Америкийн Нэгдсэн Улс, Тайландын Хант Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Япон улс, Казакстан улсын төлөөлөгчдийг хүлээн авч "ICT EXPO 2023" арга хэмжээнд оролцуулахад дэмжлэг үзүүлж ажилласан.<br>3."Цахим танилтын тогтолцоог шинэчлэх" төслийн хүрээнд Бүгд Найрамдах Эстони Улсын Цахим засаглалын академийн 2 төлөөлөгчидтэй санал солилцож, "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааг танилцуулж ажилласан. | 100 |
| 43. | Төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах | Байгууллагын үйл ажиллагааны болон зохион байгуулагч талын зардал | Хамтран ажилласан байгууллагын тоо | 0 | 20 | Төр, хувийн хэвшлийн холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Санхүүгийн | 100 |



39

40

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй Хүний ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газар, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, И-Клиник ХХК, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, И монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний Дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төв улсын үйлдвэрийн газар, 21 аймгийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн 9 дүүргийн засаг даргын тамгын газар, "Монгол шуудан" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК, Төрийн банк, Засгийн газрын авто бааз, Монголын нотариатчидын танхим, Төрийн банк ХХК, Голомт банк ХХК, Хаан банк ХХК, Анагаахын шинжлэх ухааны их сургууль, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг, "Билэгт дэлгээн" ХХК 1900-1950, "Юнител" ХХК, "Мобиком" ХХК, "Гэрэгэ систем" ХХК, "Түшиг" ХХК, "Сан энд три" ХХК, "Скай хайпермаркет" ХХК, "Да Хүрээ Трейд" ХХК, "Нисэх цагаан хаалга" ХХК, "Номин бизнес клуб" ХХК, "Олон Улсын Худалдаа Логистикийн төв" ХХК, "Хайнд Про" ХХК, "Метафорс" ХХК, "Чингис Жоней" ХХК, Фаро фаундэйшн ТББ, Ай Си Ти групп ХХК, Старт Сити ХХК, Эм Эл Си бизнес скүүл, Ай Эм Эс Эй ХХК, Эртэч Монгол ТББ, Смарт контракт ХХК, Кактус Пэй ХХК, МИАТ төрийн өмчит | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХК зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. | |
| 44. | Төрийн цахим үйлчилгээний ашиглалтыг нэмэгдүүлэх, хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах арга хэмжээг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв, цалин | Арга хэмжээний тоо | 0 | 10 | Нийслэл, орон нутагт төрийн цахим үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдад 5 сэдвийн хүрээнд цахим, танхим хосолсон хэлбэрээр сургалт зохион байгуулж нийт 300 орчим үйлчилгээний ажилтныг хамруулан ажилласан.<br>Олон нийтийн сүлжээ ашиглан төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний талаар нийт 1,201,980 хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. | 100 |
| **Зорилго 1.8 Агентлагийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, агентлагийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай санхүү, аж ахуйн үйлчилгээг үзүүлэх** | | | | | | | |
| 45. | Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах, төсвийг зориулалтын дагуу зарцуулахад дэмжлэг үзүүлэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах | - | Тайлангийн тоо | 0 | 6 | Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулж, төсвийг зориулалтын дагуу зарцуулан, төсвийн гүйцэтгэлийг тайлагнаж, төсвийн хуваарьт оруулах өөрчлөлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 5 удаа албан бичгээр хүргүүлсэн. Дээрх хүсэлтийн дагуу төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнан ажилласан. | 100 |
| 46. | Төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг гарган, аудитаар баталгаажуулах, аудитын дүгнэлтийг хэрэгжүүлэх | - | Тайлангийн тоо | 0 | 2 | “Үндэсний аудитын газар”-аас 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд асуудлын жагсаалт өгсний дагуу биелэлтийг хангaн ажилласан.<br>Монгол улсын засгийн газрын “Цахим Монгол” зорилтын хүрээнд 2023 оны | 100 |



41

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10 сарын 23-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд Үндэсний Аудитын газраас Цахим аймаг бодлогын хүрээнд Дархан-Уул аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн хийж хэрэгжүүлсэн ажлууд түүний хэрэгжилт, цахим аймгийн төсвийн зарцуулалт, үйл ажиллагаатай танилцан маш сайн үнэлэгдсэн. Үндэсний аудитын газраас Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд аудитын дүгнэлт, тайлангийн тухай мэдэгдэл хүргүүлэн ажилласан. | |
| 47. | Төсвийн шууд захирагчийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах | - | Худалдан авалтын тоо | 0 | 10 | Төсвийн шууд захирагчийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус газрын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/12 дугаар тушаалаар батлаж, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг А/11, А/94, А/70, А/22, А/24 зэрэг тушаалаар нийт 11 удаа зохион байгуулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системд холбогдох тайлан, мэдээллийг тухай бүр оруулж, гүйцэтгэлийг хангаж ажилласан. | 100 |
| 48. | Төсвийн шууд захирагчийн төсөвт батлагдсан тухайн төсвийн жилд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянан, санхүүжилтийг шийдвэрлүүлэх | - | Хүргүүлсэн баримтын тоо | 0 | 10 | Төсвийн шууд захирагчийн төсөвт батлагдсан тухайн төсвийн жилд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянан санхүүжилтийн эрх нээлгэх тухай зэрэг нийт 11 удаагийн албан бичгийг "Цахим хөгжил, харилцаа холбооны яам"-д хүргүүлж, санхүүжилтийг тухай бүр олгон ажилласан. | 100 |
| 49. | Дээд газрын тогтоол, шийдвэрийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон | - | Хүргүүлсэн саналын тоо | 0 | 6 | Хууль, тогтоол, шийдвэрийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулах | | | | | газрын нийт албан хаагчдын цалин болон хоол унааны төсвийг нэмэгдүүлэх тухай санал боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/33, 4 дүгээр сарын 6-ны өдрийн 01/73 дугаартай албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд тус тус хүргүүлж шийдвэрлүүлсэн. | |
| 50. | Эд хөрөнгийг худалдан авах, балансаас балансdefinitely шилжүүлэх, актлах, худалдахтай холбоотой харилцааг зохион байгуулах | - | Хурлын тоо | 0 | 2 | Тус газрын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/016 дугаар тушаалаар "Өмч хамгаалах зөвлөл"-ийг баталж тус газарт төрийн болон орон нутгийн байгууллагаас эд хөрөнгө, тоног төхөөрөмж шилжүүлэх шийдвэр, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцож балансаас баланс хооронд шилжүүлэх шийдвэр, санал гараагүй тул Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудал үүсээгүй болно. | 100 |
| 51. | Эд хөрөнгийн тооллого хийж, бүртгэл хөтлөх | - | 2 | 0 | 2 | Тус газрын 2023 оны А/32, А/111 дүгээр тушаалаар "Эд хөрөнгийн тооллогын комисс" байгуулан, эд хөрөнгийн бүртгэл хөтөлж, хагас болон бүтэн жилээр 2 удаа тооллого хийсэн. | 100 |
| 52. | Шилэн дансны хуулийн дагуу бүртгэл хөтлөлтийг хэвшүүлэх | - | 12 | 0 | 12 | Шилэн дансны хуулийн дагуу бүртгэл хөтлөлтийг хэвшүүлж, төсвийн гүйцэтгэлийн 131 тайлан мэдээг shilen.gov.mn цахим хуудаст байршуулан ажилласан. | 100 |
| 53. | Санхүүгийн үйл ажиллагаанд систем нэвтрүүлэх | 7,9 | Программ хангамжийн тоо | 0 | 2 | Тус газрын 2023 оны А/34 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулан, дүгнэлтийг үндэслэн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдах шаардлага хангасан системийг нэвтрүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг хэвшүүлэн ажиллаж байна.<br>Мөн эд хөрөнгийн тооллого хийх Unicus системийг нэвтрүүлсэн | 100 |



43

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бөгөөд тус системээр нийслэл, орон нутаг дахь нийт албан хаагчдын тоног төхөөрөмж дээр QR код байршуулан эд хөрөнгийн тооллогыг цахим хэлбэрээр хийсэн. | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ҮЗҮҮЛЖ БАЙГАА ЭСЭХЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилго 2.1 Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах** | | | | | | | |
| 54. | Салбарын хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, дотоод журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах | - | Хэрэгжилтийн тоо | 0 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, нийтлэг журам, Стандарт хэмжил зүйн газрын Үйлчилгээний стандарт, Үйлчилгээний ажилтны түр журам, Томилолтын заавар, Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам, Цахим гарын үсгийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус газрын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/106 дугаар тушаалаар "Кибер аюулгүй байдлыг хангах журмын төсөл боловсруулах" ажлын хэсгийг 2024 оны нэгдүгээр улиралд багтаан батлахаар ажиллаж байна.<br>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын хүрээнд тус газрын стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлын хэсгийг А/99 дүгээр тушаалаар байгуулсан.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/85 дугаар тушаалаар батлагдсан Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан. | |
| 55. | Салбарын хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох журам батлах | - | Журмын тоо | | 2 | Тус газрын 2023 оны А/28 дугаар тушаалаар Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журмыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа "Монгол шуудан" ХК-тай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулсан;<br>Нууцын гэрээний төслийг боловсруулан батлуулж, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадварт хяналт, шалгалт хийж, илэрсэн алдаа, зөрчлийг тухай бүр арилгуулан, нууцын гэрээг үйлчилгээний ажилтнуудтай байгуулан хэрэгжилтэд нийт 3 удаа хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 56. | Төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хүргэж байгаа эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | - | Зөвлөмжийн тоо | 0 | 12 | Тагнуулын ерөнхий газарт 2 удаагийн албан бичиг хүргүүлж нийслэл, орон нутаг, хилийн чанад, хилийн боомт дахь ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийлгэн ажиллаж байна.<br>Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэхээр тус газрын албан хаагчид болон Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газрын албан хаагчдыг дотоод аудитор бэлтгэх сургалтад хамруулсан.<br>Төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хүргэж байгаа эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор "Монгол шуудан" ХК-ийн 43, "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 6 салбарын үйл ажиллагаанд нийт 13 удаа хяналт, шалгалт хийж, холбогдох байгууллага, нэгжид нийт 4 зөвлөмж, 4 дүгнэлт, нийслэл, орон нутаг дахь "ХУРДАН" цэгийн нийт 95 үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, эмх цэгцийг үнэлж, холбогдох байгууллагуудад 4, нийт 12 зөвлөмж, дүгнэлт хүргүүлсэн. | |
| 57. | Хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ хүргэж байгаа "ХУРДАН" цэгийн хэвийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд хяналт тавих | - | Зөвлөмжийн тоо | 0 | 4 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам", MNS 6984:2022 "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих шаардлага", Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/13 дугаар тушаалаар | 100 |



46

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын брэндбүүк батлах тухай”, тус газрын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам”-ын хэрэгжилтийг нийслэл дэх 16 цэг, орон нутгийн 59 цэг, хилийн чанад дахь 19 цэг, “Монгол шуудан” ХК-ийн 43 салбар, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 6 салбарт төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийсэн.<br>Хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор нийслэл дэх 16, орон нутаг дахь 59, хилийн чанад дахь 14 улсын 19 "ХУРДАН" цэгийн үйл ажиллагаанд нийт 6 удаа биечлэн болон цахим хэлбэрээр хяналт, шалгалт хийж, үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх ур чадварыг үнэлж, баталгаажуулсан. Илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр холбогдох нэгжүүдэд танилцуулан 5 удаа зөвлөмж, дүгнэлт гарган, хэрэгжилтийг хангаж, шаардлагатай цэгүүдийн байршлыг шинэчлэн тогтоож, хүртээмжийг нэмэгдүүлсэн. | |
| 58. | Төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа салбарын байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжилтэд хяналт тавих | - | Хяналт шалгалтын тоо | 0 | 4 | Төрийн цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор “Монгол шуудан” ХК-ийн 43 салбар, “Монголын цахилгаан холбоо” ХК- | 100 |



47

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ийн 6 салбарын үйл ажиллагаанд нийт 13 удаа хяналт, шалгалт хийж, холбогдох байгууллага, нэгжид 4 зөвлөмж, 4 дүгнэлтийг тус тус хүргүүлж, гарсан алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажилласан. Хамтын ажиллагааны хүрээнд "Монгол шуудан" ХК-тай хамтран баталсан удирдамжийн дагуу 10, 11, 12 дугаар сард хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. | |
| **Зорилт 2.2 Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, хүн, хуулийн этгээдийн үйлчилгээ авах мэдлэг ур чадварыг сайжруулах, сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 59. | Төрийн цахим үйлчилгээг авч байгаа хүн, хуулийн этгээдээс сэтгэл ханамжийн судалгаа авах, боловсруулах, үр дүнг тайлагнах, үйл ажиллагааг сайжруулах | - | Тайлангийн тоо | 0 | 2 | Сэтгэл ханамжийн судалгааны асуумж боловсруулах олон улсын туршлагыг судалж, судалгааны аргыг тодорхойлон, асуумж боловсруулсан. Тус асуумжийн хүрээнд төрийн цахим үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамж болон үйлчилгээний ажилтны харилцаа хандлагын талаарх судалгааг 20 үйлчлүүлэгчээс авсан.<br>"ХУРДАН" цэгээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн цахим үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамжийг тодорхойлох, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн цогц судалгааг хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг А/102 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь "ХУРДАН" цэгт ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тодорхойлох тестийг боловсруулж, нийслэл, орон нутгийн нийт 93 үйлчилгээний ажилтнаас шалгалт авч, ирээдүйн чиг хандлагыг | 100 |



48

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлоход мэргэжлийн байгууллагаар цаашид өргөн хүрээнд судалгааг хийлгэх дүгнэлт гаргасан.<br>Байгууллагын хүний нөөцөд тулгуурлан төрийн цахим үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийг судлах, үнэлэх, сайжруулах зорилгоор 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд нийслэлийн 16 цэг, 21 аймгийн "ХУРДАН" цэгээр дамжуулан нийт 4,646 иргэн /Нийслэл 1,628, орон нутаг 3,018/-ийг судалгаанд хамруулсан. Судалгааны үр дүнг холбогдох байгууллагуудад танилцуулж үйл ажиллагаар сайжруулж байна. | |
| 60. | Хүн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх | - | Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тоо | 0 | 20 | Тайлант хугацаанд 7012-2626 дугаарт үйлчилгээний ажилтантай холбоотой 18 талархал ирснийг холбогдох нэгжийн удирдлага, тухайн албан хаагчид мэдэгдсэн. Иргэдээс ирүүлсэн талархлаас дурдвал:<br>*/2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төв Шуудан дахь "ХУРДАН" цэгт ажиллаж байгаа үйлчилгээний ажилтан Ууганчимэг, Гэрэлмаа нарт талархал илэрхийлье. Би өөрөө 73 настай, тэргэнцэртэй өвгөнөө түрээд явдаг юм. Настай хүн гэж төвөгшөөлгүй хурдан шуурхай, эелдэг найрсаг үйлчилгээ үзүүллээ, их сайхан санагдаж байна. Миний талархлыг заавал дамжуулж өгөөрэй. Та бүхний цаашдын ажилд нь амжилт хүсье. /Иргэн Энхцэцэг/*<br>*/Чингэлтэй дүүргийн ЗДТГ дахь "Хурдан" цэгт ажиллаж байгаа* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *үйлчилгээний ажилтан Б.Баттуяад талархаж байна. Хурдан шуурхай үйлчиллээ. /Иргэн Анхтуяа/*<br>Мөн тус газрын үйл ажиллагаатай холбоотой 16 гомдол ирснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж ажилласан. | |
| 61. | Хүн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах | - | Зөвлөгөө, мэдээллийн тоо | 0 | 80 | Тайлант хугацаанд 7012-2626 дугаарт байршил, цагийн хуваарьтай холбоотой 58, хүсэлт 118, заавар, зөвлөгөө 45, бусад асуудлаар хандсан 16, нийт 237 хүн, хуулийн этгээдийн дуудлагыг авч, зөвлөгөө өгч, мэдээллээр хангаж, ажилласан.<br>Нийслэл, орон нутаг дахь "ХУРДАН" цэгээр дамжуулан Төрийн үйлчилгээний операторын системийн хэрэглээ, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, олон шатлалт үйлчилгээний бүрдүүлбэр болон холбогдох бусад үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд нийт 43,994 анхан шатны зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан. | 100 |
| 62. | Үйлчилгээний цэгийн байршлын хүртээмжийг сайжруулах талаар холбогдох судалгаа хийх | - | Судалгааны тоо | 0 | 9 | Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүн ам зүй, нягтаршлын талаарх судалгааг ирүүлэх хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн. Судалгааны үр дүн, хүсэлтэд үндэслэн хүн ам зүйн нягтаршлыг харгалзан нийт 43 "ХУРДАН" цэгийг нийслэлийн хэмжээнд байгуулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.<br>Орон нутагт аймгийн төвд хүн амын нягтаршлын судалгааг хийж 1-3 цэгийг нээсэн. Хүн ам ихтэй Дархан-Уул аймагт 8, Баянхонгор аймагт 5 цэгийг тус тус байгуулсан.<br>Хилийн чанадад Монгол улсын иргэд хамгийн ихээр оршин суудаг БНСУ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Япон, БНХАУ, Бүгд найрамдах Сингапур улс зэрэг 15 улсад 20 "ХУРДАН" цэгийг нэн тэргүүнд байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн.<br>Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын Цагаан хад суурьшлын бүсэд 1 "ХУРДАН" цэгийг байгуулсан. Мөн "Монгол Шуудан" ХК-ийн 43, "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн 6 цэгт "Гэрэгэ систем" ХХК-ийн киоск төхөөрөмжөөр дамжуулан 24 цагийн үйлчилгээтэй 4 цэг үйл ажиллагаа явуулж байна.<br>Тус газрын А/71 дүгээр тушаалаар "Нийслэлийн 9 дүүрэг, аймгийн нийт сумдын хэмжээнд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор нэвтрүүлэхэд шаардлагатай судалгааг гаргах, бэлтгэл ажлыг хангах" ажлын хэсэг байгуулж нийслэлийн 204 хороо, 330 сумын байршил, байр талбай, хэрэгцээ шаардлага болон бусдаар гүйцэтгүүлэхэд шаардагдах эрх зүйн орчны судалгаа хийж боловсруулан Инновац, цахим бодлогын байнгын хорооны чиглэлийн дагуу уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалт хэлэлцүүлэгт Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, ажлын алба, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны газар, хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөл, нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн удирдлага, Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын удирдлагууд тус тус оролцсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.3 Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр хүлээн авсан хүсэлтийн шийдвэрлэлтэд тогтмол дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, нэгжийг мэргэжил арга зүйгээр хангах, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр, шаардлагатай арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 63. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийн алдаа, доголдлыг илрүүлэх, дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагад мэдээлэл хүргүүлж шийдвэрлүүлэх | - | Авсан арга хэмжээний тоо | 0 | 5 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт”-д байгаа үйлчилгээг нягтлан тулгалт хийхэд 785 үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар системд нэмэлтээр нэвтрүүлэх боломжтой 375 үйлчилгээ, нэршил давхардсан 33 үйлчилгээ, системд нэвтрүүлэх боломжгүй 14 байгууллагын 56 үйлчилгээ, хассан 6 үйлчилгээ гэсэн урьдчилсан судалгаа гарсан. Тус судалгааны үр дүнд 32 байгууллагын 280 үйлчилгээг 2023 онд нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс одоогийн байдлаар 20 байгууллагын 119 үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Мөн төрийн үйлчилгээг эрэмбэлж системд нэвтрүүлэх явцад системийг сайжруулах нэмэлтээр хөгжүүлэлт хийх шаардлага үүсэж тус асуудлын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны холбогдох удирдлагад танилцуулж шийдлийг боловсруулсан.<br>Орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд процесс шинжилгээ хийх, үйлчилгээг дахин загварчлах, тусгай зөвшөөрлүүдийг шинээр цахимжуулах ажлын хүрээнд И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран тус | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын Дорноговь, Сүхбаатар, Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Хэнтий, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Өмнөговь зэрэг 10 аймаг дахь хэлтсийн албан хаагчид дэмжлэг үзүүлж, арга зүйн чиглэл өгч ажилласан. | |
| 64. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем ашиглаж үйлчилгээ хүргэж байгаа үйлчилгээний ажилтны мэдлэг ур чадварт дүн шинжилгээ хийж үйлчилгээг сайжруулах | - | Авсан арга хэмжээний тоо | 0 | 5 | Нийслэл, орон нутаг дахь "ХУРДАН" цэг, Монгол шуудан ХК-ийн салбар, Монголын цахилгаан холбоо ХК-ийн салбарын нийт 95 үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, эмх цэгцийг үнэлж, холбогдох байгууллагуудад 4 удаа зөвлөмж хүргүүлсний үндсэн дээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Нийслэл, орон нутгийн үйлчилгээний ажилтанд хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадварыг сайжруулах 4 удаагийн сургалт;<br>- 21 аймаг дахь хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтныг сургагч багшаар бэлтгэх сургалт;<br>- Нийслэл болон 21 аймаг дахь хэлтсийн "ХУРДАН" цэгийн 24 үйлчилгээний ажилтныг хөгжүүлэх сургалт;<br>- Нийслэл, орон нутгийн нийт 24 үйлчилгээний ажилтан, мэргэжилтэн албан хаагчид, удирдлагуудыг "Кибер тусгаар тогтнол" форум;<br>- Байгууллагад мөрдөгдөж байгаа хууль, журмын танилцуулга, сургалтад тогтмол хамруулан ажилласан.<br>Үйлчилгээний ажилтан, ахлах ажилтантай нууцын гэрээ байгуулан | 100 |



53

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээний хэрэгжилт, харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадварт хяналт, шалгалт хийж, илэрсэн алдаа, зөрчлийг тухай бүр арилгуулан ажилласан. | |
| **Зорилт 2.4 Салбар, нэгжийн үйлчилгээ хүргэх ажилтны шалгуур үзүүлэлтийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих** | | | | | | | |
| 65. | Үйлчилгээний ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг боловсруулах | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | Хувийн хэвшлийн байгууллагын үйлчилгээний стандарт, соёлыг жишиг болгон Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журмыг баталж, тус журамд үйлчилгээний ажилтны хандлага, харилцаа, мэдлэг, үйлчилгээ үзүүлэх ур чадварыг хэмжих 9 шалгуур үзүүлэлт бүхий үнэлгээний хуудсыг хавсралтаар баталж, мөрдлөг болгон ажилласан. | 100 |
| 66. | Үйлчилгээний ажилтны хандлага, харилцаа, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг хэмжих үнэлгээний хуудасны дагуу дүгнэлт үйлдэх | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | Үйлчилгээний ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр нийт 95 ажилтны ур чадварыг үнэлж шалган, тухайн ажилтанд танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан. Шалгалтын явцад илэрсэн алдаа зөрчлийг арилгах үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулж ажилласан.<br>"ХУРДАН" цэгээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн цахим үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамжийг тодорхойлох, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн цогц судалгааг хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг А/102 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь "ХУРДАН" цэгт ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тодорхойлох тестийг боловсруулж, нийслэл, орон нутгийн | 100 |



54

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 93 үйлчилгээний ажилтнаас шалгалт авч, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход мэргэжлийн байгууллагаар цаашид өргөн хүрээнд судалгааг хийлгэх дүгнэлт гаргасан. | |
| 67. | Ажлын байранд тавигдах шаардлага, үнэлгээний хуудасны дагуу хяналт шалгалт хийх, холбогдох нэгжид зөвлөмж чиглэл өгөх | - | Зөвлөмжийн тоо | 0 | 8 | Тус газрын нийслэл дэх 16, орон нутаг дахь 30, Монгол шуудан ХК-ийн 22, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 6 салбарт ажлын байранд тавигдах салбарын тохижилттой холбоотой дотор хаягжилт батлагдсан загварын дагуу хийгдсэн эсэх, салбарын тоног, төхөөрөмжийн бүрэн байдал, хэрэглэгч рүү харсан компьютерын дэлгэц байршсан эсэх, суурин компьютер, хэвлэгч тоног төхөөрөмж, тоон гарын үсэг, төлбөр тооцооны төхөөрөмж, иргэний үнэмлэх уншигч, хурууны хээ уншигч, интернэт байгаа эсэх, гадна хаягжилт батлагдсан загварын дагуу хийгдсэн эсэх, танилцуулгын самбар байгаа эсэх, дараалалгүй үйлчлүүлэх тэмдэглэгээ байгаа эсэх зэрэг үзүүлэлтийн дагуу нийт 10 удаа гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, холбогдох байгууллага, нэгжид 8 удаа зөвлөмж, дүгнэлт хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулсан. | 100 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 3: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ СУДАЛГАА ХИЙХ, ДАХИН ЗАГВАРЧЛАХ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ БОЛОВСРУУЛЖ, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ АЖИЛТНУУДЫГ СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 3.1 Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, байгууллагын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, үйлчилгээний дэд системийн хэвийн үйл ажиллагааг хангах, сайжруулах, хандах эрхийн удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээ хүргэх сувгийг боловсронгуй болгох талаар судлах** | | | | | | | |
| 68. | Салбарын хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, | - | Хэрэгжилтийн тоо | 0 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32[1].1 дүгээр зүйлд | 100 |



55

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дотоод журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах | | | | заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв:<br><br>Нийтийн мэдээллийн дэд бүтцийн үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлыг хэмжих, тасалдал саатлын шалтгаан магадлалыг тодорхойлох, хэвийн үйл ажиллагааг хангахад Мэдээлэл нийлүүлэгч 51 байгууллага, "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрлэлийн газар, "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрлэлийн газар хоорондын уялдаа холбоог хангаж ажилласан;<br><br>Төрийн үйлчилгээний операторын системийг сайжруулж, хөгжүүлэхэд шаардлагатай ажлыг тухай бүр "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрлэлийн газарт хүргүүлсэн;<br><br>Төрийн мэдээлэл солилцооны үндсэн системд мэдээлэл нийлүүлж байгаа мэдээлэл хариуцагч 26 байгууллага, тэдгээрийн үйлчилгээ, бусад холбогдох статистик мэдээллийн нэгдсэн хяналтын самбарыг "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрлэлийн газар, "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрлэлийн газартай хамтран хөгжүүлсэн;<br><br>"Google map" платформ дээр нийслэл, орон нутаг, хилийн чанад дахь төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийн 80 байршлын мэдээллийг оруулж иргэдэд нээлттэй болгосон;<br><br>Тус газрын 21 аймаг дахь хэлтсийн дарга нарт huduu.mn цахим хуудасны | |



56

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | модератор эрхийг олгосон. Тус цахим хуудсыг сайжруулах саналыг боловсруулж 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br><br>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 13 дугаар зүйлийн 13.1.2, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь хэсэгт заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:<br><br>Тагнуулын ерөнхий газрын зөвлөмжийн дагуу Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн техникийн холболт, сүлжээний аюулгүй байдлыг тухай бүр ханган хамтран ажиллаж байна;<br>Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Төрийн үйлчилгээний операторын системийн мэдээлэл солилцооны схем зургийг “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран боловсруулсан.<br>Мөн байгууллагын нууцлагдсан дотоод сүлжээ (VPN)-ний холболтын топологи зургийг Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран боловсруулж, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж техникийн холболт, сүлжээний аюулгүй байдлыг хангасан.<br>Кибер аюулгүй байдлын нийтлэг журмын хүрээнд Тагнуулын ерөнхий газраар эрсдэлийн үнэлгээ хийлгэх, Кибер аюулгүй байдлыг дотоод журам боловсруулан тус журмын хэрэгжилтийг ханган ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11, 18 дугаар зүйлийн 18.2.12, 18.2.13, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн;<br><br>Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын киоск төхөөрөмжид төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлж мэдээллийн эзэд өөрт хамааралтай мэдээллийн хуулбарыг цахим болон цаасан хэлбэрээр гарган авах нөхцөлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж байна. Төрийн банкны киоск машинд төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлтийг И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газартай, мэдээллийн аюулгүй байдал тал дээр Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран тус тус ажиллаж 2023 онд үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаан;<br><br>Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 20.1.3-т заасны дагуу төрийн үйлчилгээний операторын системээр хүн, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг нууцлан масктай харагддаг байх хөгжүүлэлтийн саналыг И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан;<br><br>Цахим гарын үсгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасны дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн: | |



58

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны 01/259 дугаартай албан бичгээр 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хамтран ажиллах талаар хүргүүлсэн. Хамтын ажиллагааны хүрээнд 21 аймгийн 7318 төрийн албан хаагч, хүн, хуулийн этгээдийг холбогдох сургалтад хамруулж хамтран ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-д тусгагдсан 785 үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар системд нэмэлтээр нэвтрүүлэх боломжтой 375 үйлчилгээ, нэршил давхардсан 33 үйлчилгээ, системд нэвтрүүлэх боломжгүй 14 байгууллагын 56 үйлчилгээ, хассан 6 үйлчилгээ гэсэн урьдчилсан судалгаа гарсан. Тус судалгааны үр дүнд 32 байгууллагын 280 үйлчилгээг 2023 онд нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс одоогийн байдлаар 20 байгууллагын 119 үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Мөн төрийн үйлчилгээг эрэмбэлж системд нэвтрүүлэх явцад системийг сайжруулах нэмэлтээр хөгжүүлэлт хийх шаардлага үүсэж тус асуудлын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны холбогдох удирдлагад танилцуулж шийдлийг боловсруулсан. | |



59

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 69. | Салбарын хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох журам батлах | - | Журмын тоо | | 2 | Кибер аюулгүй байдлын нийтлэг журмыг хэрэгжүүлэх хүрээнд:<br>Тус газрын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/106 дугаартай тушаалаар Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журмыг төслийг боловсруулсан.<br>Үйлчилгээний ажилтанд оператор эрх олгох, цуцлах, албан байгууллага, харьяалагдах албан тушаалтанд админ эрх нээх, цуцлах дүрэм боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. | 100 |
| 70. | Салбарын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд байгууллагын үйл ажиллагаар сурталчлах ажлын хүрээнд холбогдох системийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж ажиллах | - | Арга хэмжээний тоо | 0 | 4 | Монгол улсын Засгийн газраас дэвшүүлсэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд зохион байгуулж буй "Хөдөөгийн сэргэлт" чуулган, Монгол улсын Засгийн Газраас "Цахим аймаг" бодлогын баримт бичгийн хүрээнд Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан "Маргаашийн хот" уриатай "Ухаалаг хот" арга хэмжээ, "Алсын хараа-2050", Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжилт, бизнесийн таатай орчин бүрдүүлэх "E-Business" форум, Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хамгийн том арга хэмжээ "ICT EXPO-2023", Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн экспо "Ability Expo", "Засгийн газрын цом-2023" спорт өдөрлөг, "Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход төр, нийгэм, залуучуудын бүтээлч хамтын оролцоо-залуучуудын хөгжлийн үндэсний есдүгээр чуулган", "Улаанбаатар олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум-2023" зэрэг арга хэмжээнд "ХУРДАН" цэгийг байршуулахад системийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аюулгүй байдал, хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажилласан. | |
| 71. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас бодлогын хэмжээнд хэрэгжүүлж байгаа системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, зохицуулалт хийж ажиллах | - | Системийн тоо | 0 | 2 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2023 оны 09 дүгээр 28-ны өдрийн 01/1931 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу lavlagaa.e-mongolia.mn, tulbur.gov.mn системийг төр, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлснээс хойш 3 байгууллага нэмэгдэж нийт 49 байгууллагын админ эрх, операторын 5,743 эрх, системийн админ 5 эрх, тус тус нээгдэж 80,000 үйлчилгээ үзүүлсэн;<br>Гааль татвар, санхүү, мэдээлэл технологийн төв улсын үйлдвэрийн газраас хөгжүүлсэн татвар, торгууль, хураамжийн төлбөр тооцооны систем tulbur.gov.mn-ийг хүлээн авч төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгээр дамжуулан тээврийн хэрэгслийн татвар, торгууль, замын хураамжийн төлбөр төлөлтийн үйлчилгээг үзүүлсэн;<br>Нийтийн өргөдөл, гомдлын E-Petition.mn системийг төрийн цахим үйлчилгээний 144 "ХУРДАН" цэгээр дамжуулан иргэдээс хүлээн авч, Монгол Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран ажилласан;<br>"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хот, хөдөөгийн сэргэлт зорилтын хүрээнд хотоос хөдөө рүү шилжин суурьшигчдыг дэмжих бодлого, үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор huduu.mn цахим платформыг сайжруулахаар тус газрын 21 аймаг дахь хэлтсийн дарга нарт админ эрх олгож, системийн сайжруулалтын саналыг | 100 |



61

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>Үндэсний судалгааны нэгдсэн платформ sudalgaa.gov.mn систем дээр төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай холбоотой судалгааг оруулан ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газраас "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоолд заасан "Шил ажиллагаа"-ны хүрээнд нийтэд ил тод байхаар заасан мэдээллүүдийг нээлттэй болгох ажилд 21 аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж shilen.gov.mn системд ил тод байх мэдээллүүдийг оруулан ажилласан.<br>Дээрх 6 системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, зохицуулалтыг хариуцан ажилласан. | |
| 72. | Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан хүний тоо | 0 | 500 | Тус газраас 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хамтран ажиллах талаар 01/259 дугаартай албан бичгийг хүргүүлж, Төрийн албан хаагч, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх анхан шатны сургалтад нийт 21 аймгийн 572 байгууллагын 16,403 хүн хамрагдсан;<br>Төрөөс үзүүлж байгаа цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн албан хаагч, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх хоёр дахь шатны сургалтыг хамтран зохион байгуулах тухай тус газрын 01/323 дугаартай албан бичгээр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Энэхүү хоёр | 100 |



62

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дахь шатны сургалтад нийт 281 байгууллагын 7318 төрийн албан хаагч иргэд хамрагдсан;<br>"Цахим ур чадвар" олгох танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан сургалтад Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, Сүхбаатар дүүргийн хөдөлмөр халамжийн хэлтэс, Монгол шуудан ХК, Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Санхүүгийн зохицуулах хороо болон Банк бус санхүүгийн байгууллагын нийт 514 албан хаагч;<br>Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар баталсан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг байгууллагын нийт албан хаагчдад танилцуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж нийслэл, орон нутгийн 22,438 иргэн, албан хаагчийг сургалтад хамруулсан. | |
| 73. | Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулж байгаа чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоо, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах | - | Хамтран ажиллах байгууллагын тоо | 0 | 5 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд цуврал контент хичээлийг эхлүүлэн эхний 3 цуврал хичээлийг 2023 оны 12 дугаар сард "5G", "Үүлэн технологи", "Хиймэл оюун ухаан" зэрэг сэдвээр боловсруулан тус газрын цахим хуудас, олон нийтийн сувгаар дамжуулан иргэдэд хүргэсэн. Контент үзэлтийн тоо- 4716, | 100 |



63

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Насан туршийн боловсролын төвөөс ирүүлсэн хамтран ажиллах саналын дагуу сургалтын агуулга, хөтөлбөрийн талаар дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.<br>Тус газрын 2023 оны А/79 дүгээр тушаалын дагуу MLC TRAINER ХХК-тай хамтран нийслэлийн 9, орон нутгийн 21 буюу нийт 30 Үйлчилгээний ахлах ажилтныг "Сургагч багш"-аар бэлтгэн, Сертификат олгож нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт төрийн албан хаагч, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан.<br>Сургалт зохион байгуулж байгаа чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоо, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн төв улсын үйлдвэрийн газар, Фаро фаундэйшн ТББ, Ай Си Ти групп ХХК, Смарт сити ХХК, Эм Эл Си бизнес скүүл, Ай Эм Эс Эй ХХК, Эртэч Монгол ТББ зэрэг байгууллагатай хамтран ажилласан. | |
| 74. | Нийтийн мэдээллийн дэд бүтцийг сайжруулах ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | - | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэвийн найдвартай үйл ажиллагаа | 0 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэвийн найдвартай үйл ажиллагаа | Мэдээлэл хариуцагч 51 байгууллагатай уулзалт зохион байгуулж, сервисийн тасалдал, үйлчилгээний тоо болон бусад холбогдох мэдээллийг хянах самбар хөгжүүлэлтийг И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран ашиглалтад оруулсан. | 100 |



64

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хангагдсан эсэх | | хангагдсан байна. | 1. Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийн алдааны кодын тайлбарыг дахин загварчилж, төрийн үйлчилгээний операторын систем (2.0) болгон нэршлийг өөрчилж, системд гарч байгаа алдаа доголдлыг тухай бүр И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт мэдэгдэж, хэрэгжилтийг хангуулсан;<br>2. Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн техникийн холболт, сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна;<br>3. Мэдээлэл нийлүүлэгч байгууллагын системийн гэмтэл, саатлыг хэмжих, тасалдал саатлын шалтгаан магадлалыг тодорхойлж, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлсэн;<br>4. Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгт ашиглагдаж байгаа ПОС төхөөрөмжийн алдаа, доголдлыг тухай бүр Сангийн яам, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Кактус Пэй ХХК-д тухай бүр мэдэгдэж хэрэгжилтийг хангуулан ажилласан;<br>5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Хайнд про ХХК-тай хамтран Цахим хэлмэрч программыг | |



65

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгт нэвтрүүлэхээр ажилласан.<br><br>ХУР, ДАН системийн гэрээний эрхийг агентлагт шилжүүлэх, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн хөгжүүлэлт, сайжруулалтын талаар саналыг боловсруулж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт танилцуулсан. | |
| 75. | Үйлчилгээний ажилтан бэлтгэх, дадлагажуулах, мэргэшүүлэх танхим, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сайжруулах | - | Тухай бүрд | 0 | Үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх чадавх 70%-аас багагүй болсон байна. | Тус газрын үйлчилгээний ажилтны төрийн үйлчилгээний операторын системийн анхан шатны сургалтын хөтөлбөрийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр;<br><br>Үйлчилгээний ажилтныг чадавхжуулах хоёр дахь шатны сургалтын хөтөлбөрийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр;<br><br>Үйлчилгээний ажилтныг чадавхжуулах "Хувь хүний" цогц сургалтын хөтөлбөрийг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр;<br><br>Тус газрын 21 аймаг дахь хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтныг "Сургагч багш"-аар бэлтгэх сургалтын хөтөлбөрийг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр;<br><br>Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр;<br><br>Тус газрын 21 аймаг дахь хэлтсийн "Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх" нэг дүгээр | 100 |



66

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатны сургалтын хөтөлбөрийг 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдөр;<br><br>Тус газрын 21 аймаг дахь хэлтсийн "Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх" хоёр дугаар шатны сургалтын хөтөлбөрийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр;<br><br>Сумдад төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн, хулийн этгээдэд төрөөс үзүүлж байгаа цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, төрийн албан хаагчийн, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтын удирдамжийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр;<br><br>Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газарт 01/370 дугаартай албан бичгээр хүргүүлсэн "Төрийн албан хаагч болон иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх анхан шатны сургалтын хөтөлбөр"-ийг 2023 оны 12 дугаар 05-ны өдөр;<br><br>Оюутан, сурагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, нийт 10 хөтөлбөрийг тус тус баталсан. | |
| 76. | Хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ хүргэж байгаа "ХУРДАН" цэгийн системийн бэлтгэл ажил, аюулгүй байдлыг хангах, хяналт тавьж ажиллах | - | Цэгийн тоо | 0 | 200 | Нийслэл, орон нутаг, хилийн боомт, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын нийт 144 "ХУРДАН" цэгийн системийн бэлтгэл ажил, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.<br>Нийслэл, орон нутаг, Монгол шуудан ХК, Монголын цахилгаан холбоо ХК, | 100 |



67

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын 20 цэгт нийтдээ 1,743 алдаа, доголдлыг шуурхай шийдвэрлэж заавар, зөвлөгөөг өгч ажилласан. | |
| 77. | Төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах | - | Хамтран ажиллах байгууллагын тоо | 0 | 3 | Lavlagaa.e-mongolia.mn системд админ эрх нээхтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газар, Гааль татвар, санхүү, мэдээлэл технологийн төв улсын төсөвт үйлдвэрийн газар, Төрийн банк ХХК, Голомт банк ХХК, Хаан банк ХХК, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Гэрэгэ ХХК, Метафорсе ХХК, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар, И-Клиник ХХК, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Хайнд про ХХК, Юнител групп ХХК, Монголын нотариатчидын танхим, Чингис Жоней ХХК, Улаанбаатар буян ХХК, Смарт Контракт Монголиа ХХК, Кактус Пэй ХХК зэрэг байгууллагатай төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан. | 100 |
| 78. | Системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | - | Хамтран ажилласан байгууллагын тоо | 0 | 3 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 19 дүгээр хурлын тэмдэглэлийн дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Тагнуулын ерөнхий газар, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар, Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран систем, сүлжээний аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг тогтмол хангаж ажилласан. | 100 |



68

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу төрийн үйлчилгээний операторын системийн мэдээлэл солилцооны схем зургийг И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран боловсруулсан. Мөн байгууллагын нууцлагдсан дотоод сүлжээ (VPN)-ий холболтын топологи зургийг Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран боловсруулж, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэн техникийн холболт, сүлжээний аюулгүй байдлыг ханган ажилласан. | |
| 79. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийн нэгдсэн хяналтын самбарыг хөгжүүлж нэвтрүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж хяналт тавих | - | Хяналтын самбарын тоо | 0 | 1 | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийн нэгдсэн хяналтын самбарыг хөгжүүлж нэвтрүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах, хяналт тавих ажлын хүрээнд:<br>Системийн хяналтын самбарт шаардагдах мэдээллийг авч боловсруулалт хийсэн;<br>Системийн UI, UX-г сайжруулахад холбогдох саналыг нэгтгэн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлж ажилласан;<br><br>Системд нэвтрэх админ эрхийн үүргийг ангилан хуваарилж, эрх олгох, цуцлах зөвшөөрлийн хуудсыг албажуулан бүртгэл хөтөлж, гарсан зөрчлийг тухай бүр залруулан ажилласан;<br><br>Төрийн үйлчилгээний операторын системд гарч буй алдаа, доголдлыг шийдвэрлэх, сайжруулах талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академи улсын төсөвт | 100 |



69

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрийн газарт тус тус албан бичиг хүргүүлсэн. | |
| 80. | Холбогдох байгууллагуудтай хамтран олон улсын стандарт нэвтрүүлж төрийн үйлчилгээг сайжруулах | 16,6 | Стандарт нэвтрүүлэх тоо | 0 | 2 | Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо" ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэхээр Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газрын албан хаагчдыг дотоод аудитор бэлтгэх сургалтад хамруулсан. | 100 |
| **Зорилт 3.2 Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бодлого, стратеги төлөвлөх, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх талаар судлах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төрийн үйлчилгээ хүргэх ажилтныг сургах, төлөвлөгөө боловсруулах, мэргэшүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагаас сургалт авах, холбогдох бусад арга хэмжээг хамтран тогтмол зохион байгуулах** | | | | | | | |
| 81. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системд төрийн үйлчилгээг эрэмбэлж, тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх | - | Цахим үйлчилгээний тоо | 440 | 600 | Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 100 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-д тусгагдсан 785 үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар системд нэмэлтээр нэвтрүүлэх боломжтой 375 үйлчилгээ, нэршил давхардсан 33 үйлчилгээ, системд нэвтрүүлэх боломжгүй 14 байгууллагын 56 үйлчилгээ, хассан 6 үйлчилгээ гэсэн урьдчилсан судалгаа гарсан. Тус судалгааны үр дүнд 32 байгууллагын 280 үйлчилгээг 2023 онд нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнээс одоогийн байдлаар 20 байгууллагын 119 үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Мөн төрийн үйлчилгээг эрэмбэлж системд нэвтрүүлэх явцад системийг сайжруулах нэмэлтээр хөгжүүлэлт хийх шаардлага үүсэж | 100 |



70

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тус асуудлын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны холбогдох удирдлагад танилцуулж шийдлийг боловсруулсан. | |
| 82. | Мэдээлэл хариуцагч байгууллагуудыг цахимжуулах судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | - | Байгууллагын тоо | 35 | 56 | Мэдээлэл хариуцагч байгууллагаас тайлант хугацаанд Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 51 байгууллагын 467 үйлчилгээг цахимжуулсан байна.<br>Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар, Шүүхийн Тамгын газар, Улаанбаатар төмөр замын мэдээллийн технологийн алба, Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газар, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар зэрэг байгууллагуудаас ирсэн санал хүсэлтийг хүлээн авч Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 12 хүсэлтийг нь шийдвэрлэсэн. | 100 |
| 83. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системд үйлчилгээ нэвтрүүлсэн мэдээлэл хариуцагч байгууллагуудтай системийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр хамтарч ажиллах | - | Байгууллагын тоо | 0 | 26 | Мэдээлэл хариуцагч 51 байгууллагуудтай системийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 2 удаагийн уулзалт зохион байгуулж, сервисийн тасалдал, үйлчилгээний тоо болон бусад холбогдох мэдээллийг хянах нэгдсэн хяналтын самбар хөгжүүлэхээр шийдвэрлэсэн. | 100 |
| 84. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем ашиглах талаар заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулах | - | Зөвлөмж, гарын авлагын тоо | 0 | 4 | Төрийн үйлчилгээний төлбөрийн төхөөрөмж болох ПОС, иргэний үнэмлэх уншигч төхөөрөмж, тоон гарын үсгийн төхөөрөмж, хурууны хээ уншигч төхөөрөмж ашиглалтын талаарх нийт 4 гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулан, үйлчилгээний ажилтныг мэдээллээр | 100 |



71

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангаж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.<br>Төрийн үйлчилгээний операторын системд хурууны хээ уншигч төхөөрөмжийг суурилуулах, ашиглах гарын авлагыг видео болон хэвлэмэл хэлбэрээр боловсруулж үйлчилгээний ажилтныг нийт 5 заавар, зөвлөмж, мэдээллээр ханган ажилласан. | |
| 85. | Хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах талаар заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулах | - | Заавар, зөвлөмжийн тоо | 0 | 3 | Төрийн цахим үйлчилгээ үзүүлж буй "ХУРДАН" цэг, киоск төхөөрөмж, ТҮЦ машин, өөртөө үйлчлэх төхөөрөмжийн ашиглалтын талаар тус тус 4 заавар, зөвлөмж боловсруулан цахим хуудас, олон нийтийн сувгаар дамжуулан 1,201,980 хүн, хуулийн этгээдэд хүргүүлсэн. | 100 |
| 86. | Эрх бүхий этгээд, үйлчилгээний ажилтнуудад төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системд нэвтрэх эрх нээх, цуцлах, хяналт тавих | - | Нэвтрэх эрхийн тоо | 0 | 180 | Тус газрын нийслэлийн 38, орон нутгийн 115, Хилийн чанад дахь дипломат консулын газрын 47, Монгол шуудан ХК-ийн 68, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 7 үйлчилгээний ажилтны системд нэвтрэх нийт 275 эрхийг нээсэн.<br>Мөн нийслэлийн 3, Монгол шуудан ХК-ийн 29, нийт 32 үйлчилгээний ажилтны системд нэвтрэх эрхийг цуцалж бүртгэлд хяналт тавьж ажилласан. | 100 |
| 87. | Гадаад улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээг хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр сургалт хийх, холбогдох бусад арга хэмжээг тогтмол зохион байгуулах | - | Туршлага судалсан улсын тоо | 0 | 2 | Япон улсын туршлагад үндэслэсэн "Урам зоригтой ажиллах" хөтөлбөрийн дагуу "Багийн ажиллагаа", "Харилцагчийнхаа давуу талд анхаарлаа төвлөрүүлэх", "Эерэг дүгнэлтийг бусдад хэлэх болон бусдаас хүлээн авах чадвараа хөгжүүлэх", "Харилцагчаа чин сэтгэлээсээ үнэлж сайшаахын үнэ цэнийг олж мэдэх" сэдвээр | 100 |



72

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийслэлийн 20, орон нутгийн 86 буюу нийт 106 албан хаагчийг тус тус цахим болон танхим хосолсон хэлбэрээр сургалтад хамруулсан.<br>Мөн Австрали, ОХУ, Казакстан зэрэг улсуудын туршлагыг судалж үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулсан. | |
| 88. | Байгууллагын Ахлах албан тушаалтныг сургагч багшаар бэлтгэх, сургалт зохион байгуулах | 13,5 | Сертификатын тоо | 0 | 25 | Тус газрын 2023 оны А/79 дүгээр тушаалын дагуу MLC TRAINER ХХК-тай хамтран нийслэлийн 9, орон нутгийн 21 буюу нийт 30 Үйлчилгээний ахлах ажилтныг "Сургагч багш"-аар бэлтгэн, Сертификат олгож нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт төрийн албан хаагч, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан. | 100 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 4: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, САЛБАР НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЭХ, САЙЖРУУЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БАЙРШИЛ, НӨХЦӨЛИЙГ ТӨЛӨВЛӨХ, АЖИЛТНЫ МЭДЛЭГ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ХАРИЛЦААНЫ СОЁЛЫГ ХЭВШҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | |
| **Зорилго 4.1 Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх байршлын судалгаа хийж, үйлчилгээний цэгийг шинээр байгуулах, салбар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах** | | | | | | | |
| 89. | Салбарын хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, дотоод журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах | - | Хэрэгжилтийн тоо | 0 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹.1 дүгээр зүйлд заасны дагуу төрийн цахим үйлчилгээг нийслэлд 16, орон нутагт 59, хилийн чанадад 20, Монгол шуудан ХК-ийн салбарт 43, Монголын цахилгаан холбоо ХК-ийн салбарт 6, нийт 144 цэгийг байгуулж тус ХУРДАН цэгээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэн ажилласан.<br>Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт заасны дагуу Төрийн үйлчилгээний | 100 |



73

74

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүсэлтийн бүртгэл хяналтын системээр дамжуулан тоон гарын үсгийг ашиглан хүн, хуулийн этгээдийг таньж, баталгаажуулан ажилласан.<br>Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан.<br>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх хэсэгт заасан нийтлэг журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.<br>Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам", MNS 6984:2022 "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих шаардлага", Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/13 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын брэндбүүк батлах тухай", Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын тус газрын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам"-ын хэрэгжилтийг нийт үйлчилгээний ажилтан (оператор) ханган ажилласан. | |
| 90. | Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хүн амын нягтаршил, төвлөрөл ихтэй | - | Судалгааны тоо | 0 | 2 | Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүн ам зүй, нягтаршлын талаарх судалгааг ирүүлэх хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн. Судалгааны үр дүн, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын судалгаа хийх, төрийн үйлчилгээг оновчлох | | | | | хүсэлтэд үндэслэн хүн ам зүйн нягтаршлыг харгалзан нийт 43 "ХУРДАН" цэгийг нийслэлийн хэмжээнд байгуулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн Монгол Шуудан ХК 43 цэг, Монголын цахилгаан холбоо ХК 6 цэг, Гэрэгэ систем ХХК-ийн 4 киоск төхөөрөмжөөр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэн ажилласан.<br>2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар байгуулагдсан "Нийслэлийн 9 дүүрэг, аймгийн нийт сумдын хэмжээнд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор нэвтрүүлэхэд шаардлагатай судалгааг гаргах, бэлтгэл ажлыг хангах" ажлын хэсэг байгуулагдаж Нийслэлийн 204 хороо, 330 сумын байршил, байр, талбай, хэрэгцээ шаардлага болон бусдаар гүйцэтгүүлэхэд шаардагдах эрх зүйн орчны судалгааг хийж боловсруулан Инновац, цахим бодлогын байнгын хороонд танилцуулсан. | |
| 91. | Хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэх үйлчилгээний ажилтнуудыг дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтад хамруулах | - | Үйлчилгээний ажилтны тоо | 0 | 209 | Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйлчилгээний ажилтны ур чадварыг тогтмол дээшлүүлэх, мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор Төрийн үйлчилгээний операторын системийн анхан шатны сургалт, дадлагажуулах, харилцаа, хандлагын сургалт, "Хэрэглэгчийн үйлчилгээ", "Аз жаргалтай, ажиллаж амьдрах", "Сэтгэл хөдлөлөө удирдах", "Өөртөө итгэлтэй харилцаа", "Багийн хэцүү гишүүд", "Хэцүү харилцагчтай ажиллах", "Үе | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хоорондын ялгааг таньж мэдэх", "Үр дүнтэй баг бий болгох", "Урам зоригтой ажиллах", "Цахим хөгжлийн багц хууль", сургагч багш бэлтгэх хөтөлбөр, Гамшгийн талаар ерөнхий болон анхан шатны ойлголт өгөх, Албан бичиг боловсруулах арга зүй, Ёс зүйн талаар ойлголт, түүний ач холбогдол зэрэг агуулгын хүрээнд танхим болон цахим хэлбэрээр нийслэлийн 22, орон нутгийн 81, Монгол шуудан ХК-ийн 58, Монголын цахилгаан холбоо ХХК-ийн 12 үйлчилгээний ажилтныг дадлагажуулах, чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулсан.<br><br>Дээрх сургалтад давхардсан тоогоор нийт 507 үйлчилгээний ажилтан хамрагдсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах ур чадвар"-ын сургалтад Төрийн цахим үйлчилгээний нийт 84 албан хаагчдыг танхим болон цахим хэлбэрээр хамруулсан. | |
| 92. | Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тохижилтын судалгаа гаргах | - | Судалгааны тоо | 0 | 2 | Нийслэл, орон нутаг, хилийн чанад дахь "ХУРДАН" цэгт үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгааг 2023 оны 2, 4 дүгээр сард тус тус боловсруулж, хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тус газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар Нийслэл, орон нутаг, хилийн чанад дахь нийт 95 "ХУРДАН" цэгийн гадна | 100 |



76

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон дотор тохижилтын ажлыг бүрэн зохион байгуулан ажилласан. | |
| 93. | Хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэх "ХУРДАН" төв болон цэгийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэвийн үйл ажиллагааг хангах | - | Үйлчилгээний цэгийн тоо | 0 | 120 | Нийслэлийн 16, орон нутгийн 59, хилийн чанадын 20, Монгол шуудан ХК-ийн 43, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 4, нийт 120 цэгийн нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын дарга, гишүүд, сайд нар, Аймаг сумдын удирдлага, хамтран ажиллагч байгууллагын удирдлагууд оролцсон. Төрийн үйлчилгээний операторын системээр дамжуулан нийслэлийн 16 "ХУРДАН" цэгээр нийт 94,738, орон нутагт 241,307, хилийн чанадад 2,416, Монгол шуудан ХК-ийн 43 салбарт байрлах "ХУРДАН" цэгээр 8,559, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 6 салбарт байрлах "ХУРДАН" цэгээр 3,575 нийт 350,595 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн. | 100 |
| 94. | Төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах | - | Хамтран ажилласан байгууллагын тоо | 0 | 20 | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Нийслэл, орон нутгийн хүн амын төвлөрөл ихтэй болон алслагдсан байршилд цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн 18, төрийн 20, нийт 38 байгууллага мөн Гадаад харилцааны яамны Консулын газартай хамтран хилийн чанадын 15 улсын 20 Дипломат төлөөлөгчийн газарт төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийг нээхтэй холбогдуулан хамтран ажилласан.<br>Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг, Улсын нэгдүгээр төв | 100 |



77

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлэг, "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК, "Да Хүрээ Трейд" ХХК /Да хүрээ худалдааны төв/, "Түшиг" ХХК /Улаанбаатар их дэлгүүр/, "Нисэх цагаан хаалга" ХХК /Хан плаза худалдааны төв/, "Олон улсын худалдаа логистикийн төв" ХХК /22-ын товчоо/, "Номин бизнес клуб" ХХК /Баянхошуу номин салбар/, "Сан Энд Три" ХХК /Улиастайн нэгдсэн зах/, "Скайхайпер маркет" ХХК /И-март худалдааны төв/ зэрэг төр хувийн хэвшлийн байгууллагуудтай төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан. | |
| **Зорилт 4.2 Үйлчилгээний ачаалал, хүртээмжийн талаар судалгаа хийх, ачааллыг тэнцвэржүүлэх, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 95. | Нийслэл, орон нутгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний талаар судалгаа хийж, ачааллыг тэнцвэржүүлэх ажлыг зохион байгуулах | - | Судалгааны тоо | 0 | 1 | 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 2,084,999, өдөрт дунджаар 8,407 төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн тоон үзүүлэлт бүхий судалгаа гарсан.<br>Нийслэлийн хэмжээнд 2023 оны 3 дугаар сараас, орон нутгийн хэмжээнд 4 дүгээр сараас "ХУРДАН" цэгийг үе шаттайгаар байгуулснаар 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийслэлийн хэмжээнд 16 цэгээр 91,307 үйлчилгээ буюу нэг цэг дунджаар 5,706 үйлчилгээг үзүүлснээр төвлөрлийг сааруулж, ачааллыг тэнцвэржүүлэн ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээг 2022 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн хэмжээнд 3,956 удаа хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн бөгөөд тус газар нь 2023 оны 3 дугаар сараас эхлэн 21 аймагт ХУРДАН цэгийг нээснээр 81 цэгт 2023 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн эцсийн байдлаар 241,307 буюу дунджаар нэг цэгт 2,925 үйлчилгээг үзүүлснээр төвлөрлийг сааруулж, ачааллыг тэнцвэржүүлэн ажилласан. | |
| 96. | Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системийг ашиглан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ хүргэх | - | Үйлчилгээний тоо | 0 | 100,000 | Төрийн үйлчилгээний операторын системээр дамжуулан нийслэлийн 16 "ХУРДАН" цэгээр нийт 94,738, Орон нутагт 241,307, Хилийн чанадад 2,416, Монгол шуудан ХК-ийн 43 салбарт байрлах "ХУРДАН" цэгээр 8,559, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 6 салбарт байрлах "ХУРДАН" цэгээр 3,575 нийт 350,595 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн. | 100 |
| 97. | Төрийн үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх | - | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | 0 | 30,000 | Нийслэл, орон нутгийн "ХУРДАН" цэгээр дамжуулан Төрийн үйлчилгээний операторын системийн хэрэглээ, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, олон шатлалт үйлчилгээний бүрдүүлбэр болон бусад холбогдох үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд нийт 48,796 анхан шатны зөвлөгөө, мэдээлэл, хүргэн ажилласан.<br>Мөн цахим хэлбэрээр буюу 25 дугаар суваг телевиз /Channel 25 television/, www.unuudur.mn цахим хуудас, олон нийтийн сүлжээ, "Өнөөдөр" сониноор тус тус дамжуулан нийт 30,800 иргэнд төрийн цахим үйлчилгээний талаар зөвлөгөө өгч, мэдээллээр хангасан.<br>Тайлант хугацаанд 7012-2626 дугаарт байршил, цагийн хуваарь 58, хүсэлт 118, заавар, зөвлөгөө 45, бусад асуудлаар хандсан 16, нийт 237 хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, талархал, саналыг | 100 |



79

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний албан хаагчид тухай бүр мэдэгдэж ажилласан. | |

*Төлөвлөгөөг хянасан:*
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд

***Төсвийн Ерөнхийлөн захирагч***
........................ /Н.Учрал/
..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:*
Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дарга

***Төсвийн Шууд захирагч***
........................ /П.Батбаатар/
..............................